

# Living the LOTUS

Buddhism in Everyday Life



Үүсгэн байгуулагчийн сургаал

## Бэрхшээлтэй нүүр тулах чадвар

Намайг Токиод ирээд удаагүй байхад, нэгэн үзэсгэлэн яармаг дээр үзмэрч “Чи бол ямар нэг сэдэл, нөлөө үзүүлэх зүйл байхгүй л бол болдоггүй хүн байна.” гэж хэлж байсан удаа бий. Түүнээс хойш би бэрхшээлтэй асуудалтай тулгарах бүртээ “Сонирхолтой болоод ирэхчинээ.” хэмээн өөрөө өөртөө хэлдэг болсон.

Ер нь бол ямарваа нэг зүйлийг хариуцаж байхад өнөөг хүртэл үргэлжилж ирсэн хэв маягийг нь томоор өөрчилнө гэдэг боломжтой юм шиг хэрнээ амаргүй зүйл. Гэтэл нохой хамартаа хүрэхээр усч гэдэг шиг аргагүй байдалд орсон тохиолдолд хүн дургүй байсан ч өөрчилөхөөс өөр аргагүй болдог.

Компанид ч тэр бүтэц зохион байгуулалт нь нэгэнтээ хатуу тогтчихоор, бүгд энэ хэвээрээ ингээд яваад байж болохгүй хэмээн анзаарсан ч

янз бүрийн саад бэрхшээлээс болоод өнөөг хүртэл хийж ирсэн арга барилыг өөрчилж чаддаггүй.

Угтаа бол эдийн засгийн хямралын үе нь үндсээр нь шинэчлэх сайхан боломж юм. “Энэ хямралыг даван туулах л хэрэгтэй” гэж бүгд нэг сэтгэлээр хичээн зүтгэж чаддаг. Энэ бол “Дэвадатта нь номын сайн анд” хэмээн залбирдаг Цагаан Лянхуа Судрын үзэл санаа юм.

Хүнд хэцүү бэрхшээлийг боломжоо болгож чаддаг болчихвол айдгаа авдартаа хийлээ л гэсэн үг. Сайн, муу зүйлийн аль нь ч тохиолдсон бай “сонирхолтой болоод ирэхчинээ” хэмээн нүүр тулж чаддаг болно.

Үүсгэн байгуулагчийн сургаал 9, Х.182-183

Living the Lotus  
Vol. 170 (2019,11)

**Хэвлэсэн:** Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

**Хаяг:** Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan

**TEL:** +81-3-5341-1124

**FAX:** +81-3-5341-1224

**Email:** [living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp](mailto:living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp)

**Ахлах редактор:** Саитоо Коочироо

**Орчуулсан:** Ж.Сэлэнгэ

**Эхийг хянасан:** Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Турван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.

*Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туульцаая гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.*

## “Урамшуулан дэмжих” ба “Хичээл зүтгэл”

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч  
Нивано Ничикоо



### Бурханаас өгсөн урам, дэмжлэг

Сүсэг бишрэлийн ертөнцөд бурханы ачаар “Аврагдах” гэж их ярьдаг. Бурханы сургаалаар илэрхийлбэл, Бурхан биднийг аварч энэрэх гэсэн утгатай боловч, энэ нь зүгээр нэг “Аврал”-ыг хүлээж байвал өөрөө хүрээд ирнэ гэсэн утга биш юм.

Цагаан Лянхуа Судрын “Хувилгаан балгасаар зүйрлэхүйг өгүүлсэн бүлэг”-т “Сайтар гурван орны тамаас Хамаг олон амьтныг авран гаргамуй.” гэсэн нэг мөр бий. “Авран гаргах” гэдэг нь “Урамшуулан дэмжих” гэсэн үг юм. Судрын энэхүү өгүүлбэрийн тухай үүсгэн байгуулагч “Бурхан багшийн хэлсэн үг нь зовлон, зүдгүүрээр дүүрсэн ертөнц (Там)-өөс ямар нэг нөхцөл болзолгүйгээр гаргаж өгнө гэсэн үг бус сургаалаар дамжуулж жинхэнэ үнэнийг мэдрүүлж, тэндээс гарахыг урамшуулан дэмжиж өгнө” гэсэн үг хэмээн тайлбарлаад, “Сургаалд тулгуурласан өөрийн хүчин зүтгэлээр зовлонгийн ертөнцөөс гарах хэрэгтэй.” гэсэн алдартай үгээ хэлсэн байдаг.

Бурханы сургаалтай учирсан бид аль хэдийн мөн үргэлж сургаалаар дамжуулж Бурханы “Дэмжлэг, урамшуулал”-ыг хүртэж буй атлаа зовлон зүдгүүрийн ертөнцөөс ангижрахын тулд өөрийн хэрэгжүүлэлт чухал гэдгийг одоо л нэг юм ухамсарлана.

Ингэхэд та бүхэн дээр цухас дурдагдсан “Хувилгаан балгасаар зүйрлэхүйг өгүүлсэн бүлэг”-т гардаг шүлгийн төгсгөлийн хэсгийг мэдэх болов уу.

Тийм ээ. Та бүхний сайн мэдэх “Нийтийн буяны зориулга”-аар танил болсон судрын дараах өгүүлбэр юм. “Энэ буяныг бүгд бээр хураах болтугай. Бүх амьтан лугаа бурханы замд орж гэтлэх болтугай.”

Энэ мөр нь “Бурханд тахил өргөсний ач буяныг олон хүмүүст түгээж, бүгд хамтдаа Бурханы хязгаарт хүрэх юмсан.” хэмээн хүссэн утгатай үг бөгөөд бага зэрэг хэцүү санагдаж магадгүй ч амьдралд арай ойроор бодоод үзэх юм бол бидний байнга хэрэглэдэг хичээнгүй, хичээл зүтгэл хэмээх үг санаанд орох болно.

“Гэр бүл болон найз нөхдөөс эхлээд учран уулзах бүх хүмүүст эелдэгээр хандъя. Өглөө оройн судар уншлагаар дамжуулан өөрийн зүрх сэтгэл болон үйлээ эргэцүүлэн бодъё. Тэгээд олон хүний сайн учрал, буяны садан нь болж, хамтдаа жинхэнэ аз жаргалыг мэдэрцгээе.”

Бурханы урамшуулал, дэмжлэгийг хүлээж авснаар хэрэгжүүлэх “Өөрийн хүчээл зүтгэл” гэж юу болохыг эргэцүүлэн бодох үед, энэхүү судрын хэсэгт өгүүлэгдэх том хүсэлд тулгуурласан хичээл зүтгэл нь хамгийн түрүүнд санаанд орно.



## Хүндэтгэлтэйгээр амьдрах

“Буяны садан” гэхээр “Буяны садан, сайн анд нөхөдтэй байна гэдэг бол Бурханы мөрд орох замын талтай нь тэнцэх юм болов уу.” хэмээн асуусан шавьдаа Шагжамүни Бурхан “Тэр чинь л Бурханы мөрд орох зам мөр тэр чигээрээ юм аа.” гэж тайлбарласан хэмээх яриа олонд алдартай. Тэгээд Шагжамүни Бурхан хожим энэхүү сургаалаа оршил болгож, Коосара улсын Пасээнанади хаанд эрхэм чухал зөвөлгөөг өгсөн.

“Хаантаан, та бол хүмүүс хоорондын буяны садан, сайн анд нөхөр нь болж манлайлан сайн сайхан үйлд хөтлөх хэрэгтэй. Тэгвэл таны тэрхүү хичээл зүтгэлийг харж, сонсож байгаа хэн ч хаантны ямар ч зарлигаас ч илүү хүчтэйгээр “Би ч гэсэн залхуурч хойш суулгүйгээр шаргуу ажиллая.” гэж бодох болно.” хэмээн айлдсан байдаг.

Энэ бол бидэнд ч мөн адил зориулж хэлсэн зөвлөмж билээ. Эцэг эх хүүхдийнхээ аз жаргалын төлөө бат зогсож, урамшуулахдаа юун түрүүнд өөрөө яг ямар хүн болмоор байгаа вэ гэсэн “Сэтгэлийн хүсэл, эрмэлзэл”-ийг нь чухалчлан авч үздэгтэй ижил яриа юм. Гагцхүү “Сайн сайхан зүйлийн төлөө шаргуу ажиллах” гэж юу вэ гэвэл, тэр бол амьдралын явц дахь мэдээжийн зүйлийг орхигдуулалгүйгээр өдөр бүрийг хүндэтгэлтэйгээр амьдрах явдал биз ээ.

Хэний ч хувьд одоо байгаа тэр л газар нь Бурханы мөрд орох “доожоо буюу бэлтгэл хийх газар” нь учраас үргэлж мэдээжийн зүйлийг ч нэг бүрчлэн талархан үйлдэж, эргэн тойрны хүмүүстэйгээ хамтдаа сэтгэлээ ариусган, аз жаргалыг мэдрэх. Тэр бол “Хичээл зүтгэл” бөгөөд “Бүх амьтан лугаа Бурханы замд орох болтугай” гэсэн үг.

Ингэхэд бид заримдаа алгуурлан, мэдээжийн зүйлийг ч хийж чадахгүй байх үе бий. Тэр үед бидний түшиг тулгуур болох зүйл бол санаа зорилго, хүсэл эрмэлзэл юм. “Түүн шиг болох юмсан.” хэмээн хүсч мөрөөддөг хүн шигээ болохыг зорин, шантралгүйгээр цааш үргэлжлүүлэн алхах хэрэгтэй. Бүх хүнд жинхэнэ аз жаргалыг хүсдэг Бурханыг төсөөлөн, бусдын “Буяны садан” нь болохсон гэж залбираарай.

«Косей»2019 оны 11 дугаар сарын дугаар



# Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар

## Эрдэнэсийн суварга үзүүлснийг өгүүлэх 11 дүгээр бүлэг (Сүүлийн хагас)

### Арван зүгийн Бурхадын цуглаан


Тэгээд Шагжамүни Бурхан бээр Их Номлохуйд Баясагч Бодисадвагаас эхлээд бусад олон Бодисадва нарын хүсэлт, залбирлын дагуу арван зүгийн ертөнцийн өөрийн хувилгаан биеийг цуглуулдаг. Замбуутив төдийгүй сансар огторгуй бүхэлдээ Бурхан Багшийн хувилгаан биеэр дүүрэхийг харсан Шагжамүни Бурхан тэр дороо тэнгэрт хөөрөн гарч, Эрдэнэсийн суваргын өмнө тогтоно.

### Туйлын үнэнийг амьдруулах хүч

Тэгээд баруун гараар (Билиг оюуны бэлгэдэл болсон) Эрдэнэсийн суваргын үүдийг нээхэд түүн дотор яг гүн гүнзгий бясалгалд орсон мэт Түүнчлэн Ирсэн Олон Эрдэнэт бурхан бээр огтоос хөдөлгөөнгүй заларч буй төрх харагдав.

Тэгтэл Түүнчлэн Ирсэн Олон Эрдэнэт тэр дороо ам нээн, “Гайхалтай. Үнэхээр гайхалтай. Түүнчлэн Ирсэн Шагжамүни Бурхан бээр энэхүү Цагаан Лянхуа Судрыг айлдсан нь сайн хэрэг боллоо.” хэмээн магтана.

Энэ үйл явдал ч маш чухал утгыг илэрхийлж байна. Жинхэнэ үнэний төгс дүр болсон Түүнчлэн Ирсэн Олон Эрдэнэт бурхан бээр огтоос хөдөлгөөнгүй сууж буй нь, “Туйлын үнэн бол эгнэгт хувирашгүй юм.” гэсэн утга юм. Харин гүн бясалгалд орсон мэт хөдөлгөөнгүй болсон гэдэгт бидний амьдралыг өөрчлөх хүч үгүй. Түүнийг айлдах хүн оршин байж, хүн төрөлхтний сэтгэл зүрхэнд хоногшсон цагт л хүний ертөнцийн аврал нь болох болно. Тиймээс л туйлын үнэн болсон Түүнчлэн Ирсэн Олон Эрдэнэт Бурхан бээр тэрхүү үнэнийг айлдаж, түүнийг амьдруулах үйлийг хийсэн Шагжамүни Бурханыг магтан дуулсан юм. Өөрөөр хэлбэл “Туйлын үнэн нь өөрөө түүнийг айлдаж, олон хүмүүст ойлгуулж, амьдруулахыг хүсэж байдаг.” гэдгийг ийнхүү илэрхийлсэн хэрэг.



### Хоёр Бурхан зэрэгцэн суудалд заларсан нь

Тэр үед Олон Эрдэнэт Бурхан арслант суудлын гол дунд сууж, бие лагшнаа хагас бөхийлгөөд, “Түүнчлэн Ирсэн Шагжамүни Бурхан аа, ийшээ морилно уу.” хэмээхэд Түүнчлэн Ирсэн Шагжамүни Бурхан шууд Эрдэнэсийн суваргын дотор орж, Олон Эрдэнэт Бурхантай цуг зэрэгцэн суужээ.

Энэ үзэгдэл ч бас маш чухал утгыг илэрхийлж байгаа билээ.

Нэгдүгээрт, олон хүн Түүнчлэн Ирсэн Шагжамүни Бурханыг махан биеийг олж төрсөн хязгаартай настай хүн хэмээн боддог андуурлыг нь энэ үйл явдал тас цохин, Шагжамүни бурхан нь Түүнчлэн Ирсэн Олон Эрдэнэт лугаа адилаар төрөх үхэх хирнээ орчлонгийн хүрднээс ангижирсан Бурхан болохыг нь илэрхийлсэн хэрэг. Энэ тухай дараагийн “Түүнчлэн Ирсэний насны чинээг өгүүлэх арван зургаа дугаар бүлэг”-т тодорхой дурдагддаг бөгөөд энэ бүлэгт хараахан ил тод гараагүй байна.



Хоёрдугаарт, Номын бодит бие болох Бурхан (Олон Эрдэнийн Бурхан) ба Хувилгаан Биет Бурхан Багш (Ялж Төгс Нөгчсөн Шагжамүни Бурхан) нь адил тэгш болохыг илэрхийлсэн. Өөрөөр хэлбэл “Жинхэнэ үнэн” ба “Жинхэнэ үнэний тухай айлдагч” нь адилхан үнэ цэнэтэй гайхамшигтай оршихуун мөн гэдгийг илэрхийлсэн сургаал юм.

### Бурханы сургаал өнө мөнхөд оршиж, түгэн дэлгэрнэ

Түүнчлэн Ирсэн Олон Эрдэнэт ба Түүнчлэн Ирсэн Шагжамүни бурхан хоёр тэнгэрт хөвж буй Эрдэнэсийн суваргын арслант сууринаа заларч буйг харсан олон түмэн “Бурхан нь үнэхээр өндөр хийгээд хол газар залардаг ажээ. Бид ч бас Түүнчлэн Ирсэн Бурханы хувилгаан хүчээр тэдний байгаа газарт очихсон” гэсэн хүслийг нь тээдэг. Тэр хүслийг нь мэдэрсэн Шагжамүни Бурхан тэр дор нь бүгдийг тэнгэр огторгуй өөд гаргаж өгдөг. Тэгээд “Та бүхэнд одоо л хэлье. Намайг нөгчсөний дараа энэхүү сургаалыг чанд сахиж, уншин түгээх хүн хэн бэ. Тэр хүн одоо миний өмнө тангаргаа өргөнө үү.

Угаас Түүнчлэн Ирсэн Олон Эрдэнэт бурхан нь өнө эрт цагт бурхан болсон боловч Цагаан Лянхуа Судрыг айлдахад зайлшгүй гарч ирж, түүнийг үнэн зөв гэж батлана гэсэн тангарагтай тул ийнхүү дүр төрхөө ил гарган, их дуу гаргадаг. Энэхүү Түүнчлэн Ирсэн Олон Эрдэнэт бурхан ба би, миний хувилгаан биет Бурхад хэмээх гурван зүйлийн утгыг сайтар ойлгох хэрэгтэй.

Олон шавь нар минь ээ. Хэн чинь энэхүү сургаалыг сайтар сахин хамгаалах вэ? Одоо л их хүслийг тээн, энэхүү сургаалыг ирээдүйд өнө мөнхөд үлдээх хүн гарч ирээсэй гэж хүснэ. Хэрэв энэхүү Цагаан Лянхуа Судрын номлолыг сайтар сахин хамгаалж чадах хүн байвал тэр хүний үйлдэл нь намайг болон Түүнчлэн Ирсэн Олон Эрдэнэт бурханыг тахисантай ижил болно.” гэжээ. Шагжамүни Бурханы энэ уриалгыг “Бурханы сургаал өнө мөнхөд оршиж, түгэн дэлгэрнэ” гэнэ.

### Зургаан бэрх, есөн буян

Энэ мэтчилэн нийтэд Цагаан Лянхуа Судрын сургаалыг түгээхийг уриалж, хөхүүлэн дэмжихтэй зэрэгцээд Шагжамүни Бурханыг нас нөгчсөний дараа Цагаан Лянхуа Судрыг түгээн дэлгэрүүлэх нь төсөөлөхийн аргагүй бэрх тул Цагаан Лянхуа Судрыг түгээхийн ач буян хичнээн агуу болохыг номложээ. Үүнийг “Зургаан бэрх, есөн буян” гэнэ. Зургаан бэрх гэдэг нь сургаалыг айлдахын бэрх, бичгээр үлдээхийн бэрх, уншихын бэрх, номлолыг айлдахын бэрх, сонсож хүлээж авахын бэрх, залгамжилж авахын бэрх эдгээрийг хэлнэ.





## Хоёр газар ба гурван номын хурал

Энэ хүртэлх сургаалын айлдвар нь Тас цогцолсон уулын оройд болж өнгөрсөн. Улмаар цааш “Итгэмжлэн даалгасныг өгүүлэх хорин хоёр дугаар бүлэг”-ийн төгсгөл хүртэл тэнгэрт болж үргэлжлэх ба төгсгөл нь дахин тас цогцолсон ууландаа буцаж өрнөдөг. Ийнхүү Цагаан Лянхуа Судрыг айлдахдаа уулан дээр болон тэнгэрт гэсэн хоёр газарт, гурвантаа болж буй тул “Хоёр газар ба гурван номын хурал” гэжээ. Үүнд гарцаагүй гүн гүнзгий утга агуулагдаж байна.



Уулан дээр гэдэг нь бодит байдал, тэнгэрт гэдэг нь төсөөлөл юм. Ямарч сургаал байсан эхлэл нь бодит байдалд тулгуурласан байхгүй бол ойлгоход бэрх. Иймээс Бурхан Багш ч гэсэн эхлээд явал төөрөгдлөөс зайлж, хүний амьдралын зовлонгоос ангижрах вэ гэсэн бодит асуудлаас үүдэн сургаалаа айлддаг.

Цагаан Лянхуа Судрыг ч аваад үзсэн эхэн хэсэгтээ энэ ертөнц хэрхэн оршин буйг, хүн гэж ер нь юу болохыг, хүн хоорондын харилцаа ямар байх ёстой вэ гэдгийг нэвт шувт харах билиг оюуны тухай дурддаг.

Тийм билиг оюунтай болоод ирэхээр нь төсөөллийн хязгаар буюу эцсийн зорилго хаана хүрэх вэ гэдгийг үзүүлэхгүй бол болохгүй. Өөрөөр хэлбэл Ялж төгс нөгчсөн бурхантай нэгэн бие болох хязгаар юм. Тэр бол эгэл хүний хувьд бодит амьдрал дээр олоход бэрх хязгаар билээ. Номын нөхөд (Шашны зөв байгууллага)-тэй болж, төрөл бүрийн номын үйлүүдийг хийхгүйгээр гэгээрэхэд бэрх билээ. Өөрөөр хэлбэл тэнгэрт гарч байж л хүрэх хязгаар юм.

Тэрхүү гэгээрэлд хүрээд, эргээд дахин бодит байр сууриндаа буцан, гэгээрлээ энэ хорвоо ертөнцөд хэрэгжүүлэхэд анхаарч, дахин олон олон хүмүүст нөлөөлөхгүй юм бол, хүн төрөлхтнийг бүхэлд нь аврах аврал биелэлээ эс олон, улмаар өөрийн тань аврал ч биелэгдэж чадахгүй. Тиймээс сургаалын айлдвар ч гэсэн төсөөллийн хязгаараас дахин бодит амьдрал уруу буцдаг хэрэг.

Ийнхүү Цагаан Лянхуа Судар нь үнэн зүй тогтолтой бүтцээс тогтдог ажээ.

*Нивано Никкёо “Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар /шинэ хэвлэл/”, Косей хэвлэлийн компани, 2016, X. 115-121*

## Бүх амьтан лугаа бурханы замд орж гэгээрэх болтугай

Энэ сард Үүсгэн байгуулагчийн төрсөн өдөр тохиож байгаа билээ. Мөн РКК байгууллагын хувьд бүтэн жилээ дүгнэх чухал үе юм.

Үүсгэн байгуулагч “бодитоор хүмүүсийг аварч, хорвоо ертөнцийг засан төвхнүүлэх” гэсэн хүслээр РКК-г байгуулж байсан. Түүнчлэн зөвхөн өөрийн аврал, аз жаргалыг хөөлгүй, бусдын сайн сайхны төлөө, дэлхийн энх тайвны төлөө бодит хэрэгжүүлэлт хийсэн билээ.

Нивано ерөнхийлөгч энэ сарын сургаал дээрээ Хувилгаан балгасаар зүйрлэхүйг үгүүлэх 7-р бүлгээс иш татаж, үргэлж бурханы хайр ивээлийг хүртэж буй бид учрах хүн бүртэй хүндэтгэлтэй хандаж, нөгөө хүндээ сайн учрал нь болж, хамтдаа аврагдах нь хичнээн чухал болох тухай заасан.


Сургаалтай хараахан учраагүй ойр дотны хүмүүстээ энэхүү гайхалтай сургаалыг дамжуулж, аз жаргалтай болгох хэрэгжүүлэлтээр дамжуулж, үүсгэн байгуулагчийн ач буяныг хариулцгаая!!

РКК, Олон улсын хэлтсийн дарга  
Сайтоо Кооичи



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: [living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp](mailto:living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp)

# Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



## Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, USA  
 TEL: 1-808-455-3212 FAX: 1-808-455-4633  
 Email: [info@rkhawaii.org](mailto:info@rkhawaii.org) URL: <http://www.rkhawaii.org>

## Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, USA  
 TEL: 1-808-242-6175 FAX: 1-808-244-4625

## Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, USA  
 TEL: 1-808-325-0015 FAX: 1-808-333-5537

## Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, USA  
 POBox 33636, CA 90033, USA  
 TEL: 1-323-269-4741 FAX: 1-323-269-4567  
 Email: [rk-la@sbcglobal.net](mailto:rk-la@sbcglobal.net) URL: <http://www.rkina.org/losangeles.html>

Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

- Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado**
- Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas**

## Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, USA  
 POBox 778, Pacifica, CA 94044, USA  
 TEL: 1-650-359-6951 FAX: 1-650-359-6437  
 Email: [info@rksf.org](mailto:info@rksf.org) URL: <http://www.rksf.org>

Please contact Rissho Kosei-kai of San Francisco

- Rissho Kosei-kai of Sacramento**
- Rissho Kosei-kai of San Jose**

## Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, USA  
 TEL: 1-212-867-5677 Email: [rksny39@gmail.com](mailto:rksny39@gmail.com) URL: <http://rk-ny.org>

## Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, USA  
 TEL: 1-773-842-5654  
 Email: [murakami4838@aol.com](mailto:murakami4838@aol.com) URL: <http://rkchi.org>

## Rissho Kosei-kai of Fort Myers

URL: <http://www.rkftmyersbuddhism.org>

## Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th St., Oklahoma City, OK 73112, USA  
 POBox 57138, Oklahoma City, OK 73157, USA  
 TEL: 1-405-943-5030 FAX: 1-405-943-5303  
 Email: [rkokdc@gmail.com](mailto:rkokdc@gmail.com) URL: <http://www.rkok-dharmacenter.org>

## Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago St. #809 Denver, CO 80204, USA  
 TEL: 1-303-446-0792

## Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 Kling Drive, Dayton, OH 45419, USA  
 URL: <http://www.rkina-dayton.com>

## The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First St., Suite #1, Los Angeles, CA 90033, USA  
 TEL: 1-323-262-4430 FAX: 1-323-262-4437  
 Email: [info@rkina.org](mailto:info@rkina.org) URL: <http://www.rkina.org>

## Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

(Address) 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, USA  
 (Mail) POBox 692042, San Antonio, TX 78269, USA  
 TEL: 1-210-561-7991 FAX: 1-210-696-7745  
 Email: [dharmasanantonio@gmail.com](mailto:dharmasanantonio@gmail.com)  
 URL: <http://www.rkina.org/sanantonio.html>

## Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, USA  
 TEL: 1-253-945-0024 FAX: 1-253-945-0261  
 Email: [rkseattlewashington@gmail.com](mailto:rkseattlewashington@gmail.com)  
 URL: <http://buddhistlearningcenter.org>

## Rissho Kosei-kai of Vancouver

Please contact RKINA

## Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP, CEP 04116-060, Brasil  
 TEL: 55-11-5549-4446, 55-11-5573-8377  
 Email: [risho@rkk.org.br](mailto:risho@rkk.org.br) URL: <http://www.rkk.org.br>



Facebook: <https://www.facebook.com/rishokosseikaidobrasil>  
Instagram: <https://www.instagram.com/rkkbrasil>

**Rissho Kosei-kai de Mogi das Cruzes**

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP, CEP 08730-000, Brasil

**在家佛教韓國立正佼成會**

〒 04420 大韓民國 SEOUL 特別市龍山區漢南大路 8 路 6-3  
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea  
TEL: 82-2-796-5571 FAX: 82-2-796-1696

**在家佛教韓國立正佼成會釜山支部**

〒 48460 大韓民國釜山廣域市南區水營路 174, 3F  
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea  
TEL: 82-51-643-5571 FAX: 82-51-643-5572

**社團法人在家佛教立正佼成會**

台灣台北市中正區衡陽路 10 號富群資訊大廈 4 樓  
4F, No. 10, Hengyang Road, Jhongheng District, Taipei City 100, Taiwan  
TEL: 886-2-2381-1632, 886-2-2381-1633 FAX: 886-2-2331-3433

**台南市在家佛教立正佼成會**

台灣台南市崇明 23 街 45 號  
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan  
TEL: 886-6-289-1478 FAX: 886-6-289-1488  
Email: koseikaitainan@gmail.com

**Rissho Kosei-kai South Asia Division**

Thai Rissho Friendship Foundation  
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand  
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218

**Rissho Kosei-kai of Kathmandu**

Ward No. 3, Jhamsikhel, Sanepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

**Rissho Kosei-kai of Kolkata**

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094, India

**Rissho Kosei-kai of Kolkata North**

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059, West Bengal, India

**Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center**

Ambedkar Nagar, West Police Line Road, Rumpur, Gaya-823001,  
Bihar, India

**Rissho Kosei-kai of Patna Dharma Center**

**Rissho Kosei-kai of Central Delhi**

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,  
New Delhi 110060, India

**Rissho Kosei-kai of Singapore**

**Rissho Kosei-kai of Phnom Penh**

W.C. 73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke, Khan Reouseykeo,  
Phnom Penh, Cambodia

**RKISA Rissho Kosei-kai International of South Asia**

Thai Rissho Friendship Foundation  
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand  
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

**Rissho Kosei-kai of Bangkok**

Thai Rissho Friendship Foundation  
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand  
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218 Email: info.thairissho@gmail.com

**Rissho Kosei Dhamma Foundation**

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka  
TEL: 94-11-2982406 FAX: 94-11-2982405

**Rissho Kosei-kai of Polonnaruwa**

**Rissho Kosei-kai Bangladesh**

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh  
TEL/FAX: 880-31-626575

**Rissho Kosei-kai Mayani**

Mayani Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai Damdama**

Damdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai Patiya**

China Clinic, Patiya Sadar, Patiya, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai Satbaria**

Village: Satbaria Bepari Para, Chandanaih, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai Chendhirpuni,**

Village: Chendhirpuni, P.O.: Adhunogar, P.S.: Lohagara, Chittagong,  
Bangladesh

**Rissho Kosei-kai Dhaka**

408/8 DOSH, Road No 7 (West), Baridhara, Dhaka, Bangladesh

**Rissho Kosei-kai Laksham**

Village: Dhupchor, Laksham, Comilla, Bangladesh

**Rissho Kosei-kai Cox's Bazar**

Ume Burmize Market, Tekpara, Sadar, Cox's Bazar, Bangladesh

**Rissho Kosei-kai Cox's Bazar, Ramu Shibu**

**Rissho Kosei-kai Raozan**

Dakkhin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

**Buddiyskiy khram "Lotos"**

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk 693005, Russia  
TEL: 7-4242-77-05-14

**Rissho Kosei-kai of Hong Kong**

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point, Hong Kong, China

**Rissho Kosei-kai Friends in Shanghai**

**Rissho Kosei-kai of Ulaanbaatar**

(Address) 15F Express Tower, Peace avenue, khoro-1, Chingeltei district,  
Ulaanbaatar 15160, Mongolia

(Mail) POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia

TEL: 976-70006960 Email: rkkmongolia@yahoo.co.jp

**Rissho Kosei-kai of Erdenet**

2F Ikh Mandal building, Khurenbulag bag, Bayan-Undur sum,  
Orkhon province, Mongolia

**Rissho Kosei-kai di Roma**

Via Torino, 29, 00184 Roma, Italia  
TEL/FAX: 39-06-48913949 Email: roma@rk-euro.org

**Rissho Kosei-kai of the UK**

**Rissho Kosei-kai of Paris**

**Rissho Kosei-kai of Venezia**

**Rissho Kosei-kai International Buddhist Congregation (IBC )**

166-8537 東京都杉並区和田 2-7-1 普門メディアセンター 3F  
Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan  
TEL: 03-5341-1230 FAX: 03-5341-1224 URL: <http://www.abc-rk.org>